

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр

№02

Улаанбаатар хот

"Монгол Даатгал" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тоот тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.2 дахь заалт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс 7 дугаар сарын 25-ны өдрийн 12:00 хүртэл үнэт цаасны компаниуд болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, "Монгол даатгал" ХК-ийн байранд эчнээ санал хураалтаар явуулав.

Хурлын дарга Громов С.Б.:

2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтаар "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал асуулгаар явуулах тухай" 23/14 тоот тогтоолыг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан.

Хуралд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, тус хурлыг зохион байгуулах комиссын дарга Т.Цацрал, "Гендекс" ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал М.Амар Тооллогын комиссын даргаар ажилласан. Санал хураах хайрцгийг нээж байж хурлын ирцийг тогтоох болно. Тооллогын комисс лацадсан хавтасыг нээнэ үү.

Тооллогын комиссын дарга М.Амар:

"Монгол Даатгал" ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, үүнээс 109,330 ширхэг халаасны хувьцаатай буюу саналын эрхтэй 64,023,011 ширхэг хувьцаатай, саналын хайрцагнаас нийт 3 саналын хуудас гарлаа. Нийт 269 хувьцаа эзэмшигч байгаа. "Милленниум Секьюритис Менежмент Лимитед" компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Э.Золзаяа 154 ширхэг, А.Санчирмаа 95 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,464 ширхэг хувьцаатай буюу 99,7 хувийн ирцтэй байна.

"Компанийн тухай хууль"-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулья.

Тооллогын комиссын дарга М.Амар тооллогын комиссын 23/03 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Громов С.Б.:

Хурлын ирц хүрсэн учраас Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн тогтоолыг танилцуулья.

ТУЗ-ийн тогтоолыг бүтнээр нь уншиж танилцуулав.

Хурлын дарга Громов С.Б.:

Тооллогын комиссын дарга М.Амар санал тоолох ажил дууссан бол саналын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга М.Амар:

Санал тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63,997,464 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Тооллогын комиссын дарга М.Амар тооллогын комиссын 23/04 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Громов С.Б.:


Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах шийдэрүүдийг танилцуулья.


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг 62.1.7 дахь заалт болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр хүртэл явуулсан эчнээ санал хураалтын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:
 1. Громов Сергей Борисович
 2. Огай Наталья Юрьевна
 3. Лизунова Таня
 4. Очирбатын Эрдэнэбулган
 5. Лхагважавын Төр-Од
 6. Громов Борис Сергеевич
3. Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:
 1. Очиржанцангийн Цогт
 2. Базарын Аюуш
 3. Зоригийн Хайдар
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д даалгасугай.
5. Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

Дээрх тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ. Хуралтай холбоотой сайжруулах, анхаарах зүйлс байвал хувьцаа эзэмшигчдийн хурлын комиссын дарга Т.Цацрал, хурлын дарга Громов С.Б. миний биед хандах, компанийн вэбсайтаар дамжуулан саналаа илгээх, мэдээлэл авахад нээлттэй юм шүү. Хувьцаа эзэмшигч та бүхэн компанидаа итгэх итгэлээ хадгалж, хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцож байгаад талархснаа илэрхийлье.

Тус эчнээ санал хураалтыг 12:30 минутад хаасныг мэдэгдье.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:..........Т.Цацрал

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:..........Громов С.Б.